



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЕТГ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж
ХБҮЗ	Хэлний бодлогын үндэсний зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	8
2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Зардлын данстай холбоотой асуудал	12
3.2 Зардлын данстай холбоотой асуудал	12
3.3 Балансын данстай холбоотой асуудал.....	13
3.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	Error! Bookmark not defined.
3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал	13
4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5. Хавсралт.....	21
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА З.ЭНХБОЛД
ТАНАА

2019.04.25 № 848
танай _____ -ны № _____ -т
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0425SAG10.Docx

072261

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч З.Энхболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу МУЕТГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

МУЕТГ-ын даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцан гүйцэтгэв.

МУЕТГ-ын даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2019 оны 04 дугаар сарын 04-ний өдрийн 02/235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар, аргачлалын дагуу горим сорил гүйцэтгэн, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлийг баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

МУЕТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар шинэчлэн баталгаажуулсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар “Монгол Улсын ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрэм”-ийг баталсан байна. Тус дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

МУЕТГ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулж, Ерөнхийлөгчийг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, алсыг харсан, мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээгээр хангаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийн хөтөч байхад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

МУЕТГ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг удирдлага болгон ажилладаг бөгөөд үйл ажиллагаагаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилгыг биелүүлэхэд чиглүүлж, холбогдох байгууллагуудтай нягт уялдуулан явуулж байна.

МУЕТГ-ын удирдлага болон төсвийн ерөнхийлөн захирагч дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

МУЕТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох группын “Acoulous” програмыг ашиглан боловсруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

Харин санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан ёсоор ажлын байрны тодорхойлолтод дотоод аудитын чиглэлээр үйл ажиллагаа явуулах үүрэг, чиглэл бүхий албан тушаалтан байхгүй байгаа тул тайлант онд энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй, хийгдсэн ажил байхгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад МУЕТГ-ын даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов. Энэ нь материаллаг байдлын суурийг нийт хөрөнгийн болон цэвэр хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг МУЕТГ-ын даргын төсвийн 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,487.7 сая төгрөгийн 2 хувь буюу 109.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь Төсвийн ерөнхийлөн захирагч нь сүүлийн 2 жил зөрчилгүй санал дүгнэлт авч байсан тул санхүүгийн үйл ажиллагааг эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд МУЕТГ-ын харъяа 3 ТШЗ, 1 төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №1 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч		3		
2	Төсөл хөтөлбөрийн нэгж		1		
3	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
	Дүн	1	4		

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторын А/156 дугаар тушаал

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

МУЕТГ-ын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 113.0 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлж зөрчлийг засах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

МУЕТГ-ын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт №2 (Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт. сая төгрөг)

Д/Д	Байгуул-лагын нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Ерөнхийлөгчийн төсөв /ТШЗ/	1	93.5					1	93.5	-	-	-	-		
2	ЕТГ /ТШЗ/	3	19.5			1		2	19.5						
3	ХБҮЗ /ТШЗ/	1						1							
	Нийт дүн	5	113.0			1		4	113.0						

Эх сурвалж: Аудитын горим сорилын ажлын баримт

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

МУЕТГ-ын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Өмнөх аудитын хэрэгжилттэй холбоотой асуудал

МУЕТГ-т мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл:

Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

МУЕТГ-ын даргын төсвийн санхүүгийн тайлангийн дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардалд 4,470.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 770.7 сая төгрөг, нийт 5,241.0 сая төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс 100.0 хувь санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

МУЕТГ-ын даргын төсвийн урсгал зардал 4,452.0 сая төгрөг буюу 99.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь томилолт, гадаад зочны зардал 16.9 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын зардалд 770.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 754.3 сая төгрөг зарцуулж 16.4 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Хэлний бодлогын үндэсний зөвлөл Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын зөв бичих дүрэмд үндэслэн “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг бүтээсэн байна.

Хэлний бодлогын үндэсний зөвлөл нь “Дэлхийн банкны Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс дээрх толь бичгийг хэвлүүлэхэд 276.5 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч, хэвлэлтийн зардалд 250.0 сая төгрөг, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт номыг тараах тээвэр, томилолт, урамшууллын зардалд нийт 26.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

МУЕТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

МУЕТГ-ын дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд *shilendans.gov.mn* цахим хуудасны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цонхнуудад дараах мэдээллийг байршуулж байх үүрэгтэй байна.

ҮАГ-аас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийж буй нийцлийн аудитаар МУЕТГ-ын тус хуулийн 2018 оны хэрэгжилтийг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

А. Төсөв/гүйцэтгэл цэсэнд нийт 9 төрлийн мэдээлэл байршуулахаас 2 төрлийн мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 6 төрлийн мэдээллийг зарим сард хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн;

Б. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт цэсэнд нийт 5 төрлийн мэдээлэл байршуулахаас 3 төрлийн мэдээллийг зарим сард хугацаа хоцроож мэдээлсэн, бусад мэдээллийг хугацаанд нь 100 хувь мэдээлсэн;

В. Бусад шийдвэр, үйл ажиллагаа цэсэнд 6 төрлийн мэдээлэл байршуулахаас 5 төрлийн мэдээллийг зарим сард хугацаа хоцроож мэдээлсэн, бусад мэдээллийг хугацаанд нь 100 хувь мэдээлсэн байна.

Дээрх аудитаар тус байгууллагын “Шилэн дансны тухай” хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 93.3 хувьтай гэж үнэлсэн байна,

Бид аудитын явцад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж үзлээ.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

МУЕТГ-ын даргын төсвийн санхүүгийн тайланд хийсэн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд 7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжээгүй, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу нийт 90.0 хувийн биелэлттэй гарсан байна.

МУЕТГ-ын мониторинг, дотоод хяналт хариуцсан референтийн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид МУЕТГ-ын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

МУЕТГ-ын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБООС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь МУЕТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээний зардалд 93.5 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсөв захирагч Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлээгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан МУЕТГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

МУЕТГ-ын ажилтнуудад зориулсан 2 удаагийн сургалтад 17.8 сая төгрөг зарцуулж сургалтыг зохион байгуулсан боловч гүйцэтгэлийн тайлан гаргаж үр дүнг тооцож ажиллаагүй нь ТГ-ын дэд даргын 2018 оны А/31, А/90 дүгээр тушаалуудаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй, НББ-ийн тухай хуулийн 3.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсөв захирагчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан МУЕТГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд өглөг 1.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, цаашид дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан МУЕТГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй нь НББ-ийн тухай хуулийн 18.2-т *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, нягтлан бодох бүртгэл тайлагналыг алдаатай гүйцэтгэх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Өөрийн байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж, мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан МУЕТГ-ын болон Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	622.8	132.0
АВЛАГА	113,652.4	0.1
БАРАА МАТЕРИАЛ	424,691.9	375,512.4
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	538,967.1	375,644.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	208,244.6	345,942.1
Биет хөрөнгө	208,244.6	345,942.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	208,244.6	345,942.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	747,211.8	721,586.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,730.3
Өглөг	-	1,730.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	1,730.3
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	-	1,730.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	747,211.8	719,856.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	419,275.6	419,275.6
Хуримтлагдсан үр дүн	311,413.4	284,058.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,522.7	16,522.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	747,211.7	719,856.3
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН	747,211.8	721,586.6

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,983.9	2,339.5
Нийтлэг татварын бус орлого	6,762.2	2,339.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,773,810.2	5,458,054.4
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН	4,975,794.1	5,460,393.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ /Зардлын зүйлээр/	5,175,501.6	5,487,749.3
УРСГАЛ ЗАРДАЛ	5,175,501.6	4,987,749.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,801,372.8	4,773,318.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,046,430.9	998,970.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,108.3	118,905.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,635.3	7,338.0
Хангамж, бараа материалын зардал	170,596.5	434,710.7
Нормативт зардал	4,646.1	4,950.0
Эд хогшил, урсгал засварын зардал	18,367.0	24,997.9
Томилолт, зочны зардал	1,029,983.1	1,424,187.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	238,862.0	12,692.7
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	2,546,872.5	1,960,996.1
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	5,175,501.7	4,987,749.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	500,000.0
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг (алдагдал)	(199,707.4)	(27,355.4)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(199,707.4)	(27,355.4)

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,983.9	2,339.5
Нийтлэг татварын бус орлого	6,762.2	2,339.5
Тусламжийн орлого	195,221.7	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,773,810.2	5,501,164.8
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН НИЙТ ДҮН	4,975,794.1	5,503,504.3
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,626,074.2	4,521,231.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,046,733.5	998,290.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,108.2	118,905.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,635.3	7,338.0
Хангамж, бараа материалын зардал	165,905.0	431,518.4
Нормативт зардал	4,646.1	4,950.0
Эд хогшил, урсгал засварын зардал	18,890.4	24,997.9
Томилолт, зочны зардал	963,626.1	1,352,451.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,493.7	12,692.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,064,035.9	1,570,087.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	417,239.3	214,431.3
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН МӨНГӨН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	5,043,313.5	4,735,662.7
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-67,519.4	767,841.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	59,590.8	768,332.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХУДАЛДАН АВАЛТ	59,590.8	768,332.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-59,590.8	-768,332.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	(127,110.2)	(490.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	127,733.0	622.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	622.8	132.0

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	946,919.2	0.0	946,919.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	946,919.2	0.0	946,919.2
Тайлант үеийн үр дүн	-199,707.4	0.0	-199,707.4
2017 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	747,211.8	0.0	747,211.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	747,211.8	0.0	747,211.8
Тайлант үеийн үр дүн	-27,355.4	0.0	-27,355.4
2018 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	719,856.3	0.0	719,856.3

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		622.8		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,240,996.0	5,206,354.3	34,641.7	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,470,296.0	4,452,011.0	18,285.0	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,283,719.0	4,265,595.0	18,124.0	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,294.2	998,290.2	4.0	100.0
210101	Үндсэн цалин	666,960.8	666,956.8	4.0	100.0
210102	Нэмэгдэл	249,658.4	249,658.4	0.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	81,675.0	81,675.0	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,905.2	118,905.2	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	78,973.6	78,973.6	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,982.9	9,982.9	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,986.2	7,986.2	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,996.6	1,996.6	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,965.9	19,965.9	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,344.0	7,338.0	6.0	99.9
210304	Байрны түрээс	7,344.0	7,338.0	6.0	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	165,380.9	165,288.0	92.9	99.9
210401	Бичиг хэрэг	19,049.8	19,340.7	-290.9	101.5
210402	Тээвэр, шатахуун	106,995.0	107,271.1	-276.1	100.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,336.1	38,676.2	659.9	98.3
2105	Нормативт зардал	4,950.0	4,950.0	0.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,950.0	4,950.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,995.3	30,973.7	21.6	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,375.2	6,773.3	14,601.9	31.7
210604	Урсгал засвар	9,620.1	24,200.4	-14,580.3	251.6
2107	Томилолт, зочны зардал	1,365,964.5	1,349,056.2	16,908.3	98.8
210701	Гадаад албан томилолт	1,112,742.7	1,012,419.1	100,323.6	91.0
210702	Дотоод албан томилолт	68,202.4	124,230.7	-56,028.3	182.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	185,019.4	212,406.5	-27,387.1	114.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,191.9	12,692.7	499.2	96.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,191.9	12,692.7	499.2	96.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,578,693.0	1,578,101.0	592.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,519,796.1	1,519,204.1	592.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,896.9	58,896.9	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,577.0	186,416.0	161.0	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,577.0	186,416.0	161.0	99.9

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,577.0	96,576.8	0.2	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,000.0	89,839.1	160.9	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	770,700.0	754,343.3	16,356.7	97.9
221001	Их засвар	500,000.0	500,000.0	0.0	100.0
222001	Тоног төхөөрөмж	270,700.0	254,343.3	16,356.7	94.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,240,996.0	5,205,863.5	35,132.5	99.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,240,996.0	5,205,863.5	35,132.5	99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,240,996.0	5,205,863.5	35,132.5	99.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		132.0		
5	Төсвийн тохируулга				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	3	3		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60	60		
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620004	Гэрээт ажилтан				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60	60		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	37	37		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	4	4		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11	11		

5. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо :	Аудитын нэр:	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:	САГ-2019/2/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	8	9
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээний зардалд 93.5 сая төгрөг зарцуулсан	93.5	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга, Нягтлан бодогч	Г.Байгалмаа Г.Амгалан
2	МУЕТГ-ын ажилтнуудад зориулсан 2 удаагийн сургалтанд 17.8 сая төгрөг зарцуулж сургалтыг зохион байгуулсан боловч гүйцэтгэлийн тайлан гаргаж үр дүнг тооцож ажиллаагүй	17.8	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга, Нягтлан бодогч	Г.Байгалмаа Г.Амгалан
3	Тайлант онд өглөг 1.7 сая төгрөгөөр нэмэгдсэн	1.7	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга, Нягтлан бодогч	Г.Байгалмаа Г.Амгалан
4	ЕТГ-т мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй		Албан шаардлага өгөх	Тамгын газрын дэд дарга, Нягтлан бодогч	Г.Байгалмаа Г.Амгалан
5	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй		Зөвлөмж өгөх	ХБҮЗАА-ны дарга, Нягтлан бодогч	Н.Нарангэрэл Ж.Наранчимэг
Нийт дүн		113.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 04 дугаар сарын 25

№ 05/042

Улаанбаатар хот

САГ-2019/2/СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газарт мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 2.1-д "Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино". 4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна", 4.2-д "Дотоод аудитын нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хариуцан тайлагнана" дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Үндэсний аудитын газраас хийсэн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референтийн ажлын байрны тодорхойлолтод дотоод аудитын чиглэлээр гүйцэтгэх ажлын талаар холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах;

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2019\0425SAG20.Docx

070941

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Г.Байгалмаа, нягтлан бодогч Г.Амгалан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
БИЧСЭН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР <i>Ц.Н</i> Ц.НАРАНЧИМЭГ АХЛАХ АУДИТОР <i>Л.Х</i> Л.ХОНГОРЗУЛ УХА#122	ЗӨВШӨӨРСӨН: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА <i>Г.Б</i> Г.БАЙГАЛМАА НЯГТЛАН БОДОГЧ <i>Г.А</i> Г.АМГАЛАН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2019\0425SAG20.Docx